



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/В7

Цагаан-Уул сум

Г Бүх нийтийн цэвэрлэгээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээний айл өрх, албан байгууллага, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2024 оны 05 дугаар сарын 06-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн хооронд зохион байгуулсугай.
2. Айл өрх, гудамж хороолол, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг хариуцан цэвэрлүүлэх албан байгууллагуудыг 1 хавсралтаар баталсугай.
3. Гудамж хороолол, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг ачиж зөөвөрлөх тээврийн хэрэгслийг олж хуваарьт талбайн хогийг ачуулах ажлыг зохион байгуулахыг гудамж хороолол нийтийн эзэмшлийн талбайг хариуцсан албан байгууллагуудад, хог тээвэрлэх тээврийн хэрэгслийг шатах тослох материалаар ханган ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр), Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Оюунчимэг) нарт тус тус үүрэг болгосугай.
4. Бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Жаргалант багийн Засаг дарга (Г.Ууганбаяр), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Г.Одгэрэл), Байгаль хамгаалагч (Н.Жанчивдорж), (Ч.Нямдаваа), (Н.Пүрэвбат), (Б.Ариунболд) нарт тус тус даалгасугай.
5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (У.Аварзэд)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГОНЧИГНЯМ



/Zahiramj 2024/